

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжилтийг хангаж, хавсралтаар батлагдсан маягтыг цахим татварын системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын хяналт шалгалт, арга зүйн газар /Б.Бадамцэцэг/, Мэдээллийн технологи, статистикийн төв /М.Чойжилсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/264 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Татварын алба татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хяналт шалгалт хийх, үйл ажиллагааг зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, татвар төлөгчид хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, үүсэж болох эрсдэлээс хамгаалахад энэ журмын зорилго оршино.

1.2.Татварын алба, татварын улсын байцаагч нь хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Татварын ерөнхий хуулийн 76.7-д заасан зарчмыг баримтална.

1.3.Татварын хяналт шалгалт /цаашид “хяналт шалгалт” гэх/-ын үйл ажиллагаанд олон улсын гэрээ, татварын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг, татварын албанаас баталсан дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.

1.4.Татварын алба хяналт шалгалтын явцад Татварын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нийтлэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.5.Хяналт шалгалт хийж байгаа татварын улсын байцаагч нь хяналт шалгалтын үе шатуудад хэрэгжүүлсэн үйлдэл, үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, баримт, тайлбар, үндэслэл, нотолгоо, дүгнэлт, шийдвэр зэрэг холбогдох баримт бичгийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгэнэ.

1.6. Бүх нийтийг хамарсан гамшиг, байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл бий болсон, Улсын онцгой комисс, эрх бүхий байгууллагаас зарласан бэлэн байдлын зэрэг тогтоосон үед төрийн албаны тасралтгүй байх зарчмыг хангах үүднээс тухайн нөхцөл байдалд тохируулан энэ журмын 2.11.2-т заасан хэлбэрээр татварын хяналт шалгалтыг хийж болно.

1.7.“Татварын акт” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.26-д заасныг гэж ойлгоно.

1.8. Эрсдэлд суурилсан хяналт шалгалт гэдэгт “Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны ажиллах журам” -ын 5.7-т заасан эрсдэлийн үнэлгээгээр тооцож гаргасан хяналт шалгалтыг ойлгоно.

Хоёр.Татварын хяналт шалгалтын хэлбэр, ангилал, харьяалал

2.1.Татварын алба Татварын ерөнхий хуулийн 41.4-т заасны дагуу дараах үндэслэлээр татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана.

2.1.1.эрсдэлд суурилсан;

2.1.2.татвар төлөгчийн хүсэлтээр.

2.2.Татварын албаны “Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны ажиллах журам” -ын 6.3, 6.4-т заасан үндэслэлээр энэ журмын 2.1.1-д заасан хяналт шалгалтыг хийнэ.

2.3.Татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих, алдагдал, татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулахтай холбоотойгоор татвар төлөгчөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу энэ журмын 2.1.2-т заасан хяналт шалгалтыг хийнэ.

2.4.Татварын хяналт шалгалтыг Татварын ерөнхий хуулийн 41.2-т заасны дагуу бүрэн хяналт шалгалтыг бүх төрлийн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд, хэсэгчилсэн хяналт шалгалтыг нэг буюу хэд хэдэн төрлийн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд уламжлалт болон цахим хэлбэрээр хийнэ.

2.5.Хэсэгчилсэн хяналт шалгалтын үед илэрсэн зөрчил нь бусад татварын төрөлд нөлөөлж байвал тухайн татварын төрлийг хяналт шалгалтад хамруулах, эсхүл бүрэн хяналт шалгалтыг хийнэ.

2.6.Энэ журмын 2.1-д заасан хяналт шалгалтыг түүнийг гүйцэтгэх ажлын цар хүрээнээс хамаарч дараах төрлөөр ангилна:

2.6.1. нарийн төвөгтэй хяналт шалгалт;

2.6.2. энгийн хяналт шалгалт;

2.6.3. хялбаршуулсан хяналт шалгалт;

2.7.Энэ журмын 2.6.1-д заасан хяналт шалгалтад бусад салбарын мэргэжилтэн, гадаад улсын эрх бүхий байгууллагатай хамтарч хийх, үнэ шилжилт, татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм хэрэгжүүлэх зэрэг нарийн төвөгтэй ажиллагаа хийгдэх татварын хяналт шалгалтыг хамааруулан ойлгоно.

2.8.Энгийн хяналт шалгалт гэдэгт энэ журмын 2.6.1, 2.6.3-д зааснаас бусад хяналт шалгалтыг хамааруулна.

2.9.Хялбаршуулсан хяналт шалгалтыг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл болон холбогдох бусад мэдээлэлд үндэслэн цахим болон бусад хэлбэрээр хийнэ.

(тайлант болон өнгөрсөн үеийн татварын ногдуулалт төлөлтийн байдалд-хассан)

2.9.1. хялбаршуулсан хяналт шалгалтыг Эрсдэлийн удирдлагын газраас ирүүлсэн хялбаршуулсан хяналт шалгалт хийх төлөвлөгөөнд үндэслэн энэ журмын 3.5-д заасан томилолт олгогдсоноор хийнэ.

2.9.2. хялбаршуулсан хяналт шалгалт хийх явцад татварын хууль тогтоомжийг бусад хэлбэрээр зөрчсөн, эсхүл энэ журмын 4.3.9, 4.3.10, 4.3.11, 4.3.12, 4.3.13, 4.3.14, 4.3.15, 4.4.2, 4.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэн зөрчлийг тогтоох шаардлага үүссэн тохиолдолд хяналт шалгалтын нэгжийн даргад танилцуулна. Хяналт шалгалтын нэгжийн дарга энэ журмын 3.16.7-д заасны дагуу томилолтод өөрчлөлт оруулах саналыг Эрсдлийн удирдлагын газарт хүргүүлнэ.

2.9.3. хялбаршуулсан хяналт шалгалт хийсэн нь тухайн хугацааны албан татварын ногдуулалт төлөлтийн байдалд иж бүрэн хяналт шалгалт хийхгүй байх үндэслэл болохгүй.

2.10.Татварын албаны хяналт шалгалтын нэгж нь татвар төлөгчийг харьяаллын дагуу шалгана.

2.11.Энэ журмын 2.10-т заасныг үл харгалзан дараах тохиолдолд хяналт шалгалтын харьяаллыг өөрөөр тогтоож болно.

2.11.1.татварын ерөнхий хуулийн 41.6-д заасан үндэслэлээр татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хяналт шалгалтын харьяаллыг тогтоох;

2.11.2.татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын нэгж нь Татварын ерөнхий хуулийн 41.2-т заасан тусгай удирдамжийн хүрээнд татвар төлөгчийн харьяалал харгалзахгүйгээр хяналт шалгалт хийх;

2.11.3.нийслэлийн татварын газрын хяналт шалгалтын нэгж нь дүүргийн татварын хэлтсийн харьяалах татвар төлөгчид Татварын ерөнхий хуулийн 41.2-т заасан тусгай удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийх;

2.11.4.маргаан таслах зөвлөлөөс маргаан бүхий нөхөн ногдуулалтын актыг түдгэлзүүлж буцаасан тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 47.11-д зааснаар дээд шатны татварын алба татварын хяналт шалгалт хийх;

Гурав. Хяналт шалгалтын удирдамж, томилолт, хугацаа

3.1.Татварын алба хяналт шалгалтыг Татварын ерөнхий хуулийн 41.2-д заасны дагуу хийж гүйцэтгэх бөгөөд хяналт шалгалтын ерөнхий болон тусгай удирдамжийг Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

3.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын зөвшөөрснөөр Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын нэгжийн дарга энэ журмын 3.1-д заасан тусгай удирдамжийг баталж болно.

(том татвар төлөгч хариуцсан нэгж, аймаг, нийслэлийн татварын газрын хяналт шалгалтын нэгжийн дарга-хассан)

3.3.Энэ журмын 2.6-д заасан хяналт шалгалтыг ерөнхий удирдамжаар хийж гүйцэтгэнэ. Ерөнхий удирдамжид дараах зүйлийг тусгана:

3.3.1.удирдамжийн он, сар, өдөр, нэгдсэн дугаар;

3.3.2.шалгалтын зорилго, үндэслэл

3.3.3.шалгалтын төрөл, хэлбэр;

3.3.4.шалгалтад хамрагдах хугацаа;

3.3.5.шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч;

3.3.6.шалгалт эхлэх болон дуусах хугацаа.

3.4.Энэ журмын 2.6-д заасан хяналт шалгалтыг шаардлагатай тохиолдолд тусгай удирдамжаар хийж гүйцэтгэнэ. Тусгай удирдамжид энэ журмын 3.3-т зааснаас гадна шалгалтын бүрэлдэхүүн түүнд тавигдах шаардлага, хамтарч гүйцэтгэх байгууллагын нэр зэрэг бусад шаардлагатай мэдээллийг тусгана.

3.5.Татварын алба хяналт шалгалтыг зөвхөн томилолттойгоор гүйцэтгэх бөгөөд энгийн болон хялбаршуулсан хяналт шалгалт хийх томилолтыг Эрсдэлийн удирдлагын нэгжийн төлөвлөгөөний мэдээлэлд үндэслэн тухайн албаны хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга олгоно.

3.6.Нарийн төвөгтэй хяналт шалгалт хийх татварын улсын байцаагчийн томилолтыг тухайн шалгалтыг удирдан зохион байгуулж байгаа татварын албаны хяналт шалгалтын нэгжийн даргын санал болгосноор Эрсдлийн удирдлагын нэгжийг төлөвлөгөөг үндэслэн олгоно.

3.7.Энгийн болон хялбаршуулсан хяналт шалгалтын явцад дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг энэ журмын 2.6.1-д заасан төрөл болгон өөрчлүүлэх саналыг Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжид танилцуулгын хамт хүргүүлнэ. Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж нь ирүүлсэн саналыг танилцуулгын хамт Эрсдлийн удирдлагын нэгжид хүргүүлнэ.

3.7.1. харилцан хамаарал бүхий этгээд хооронд хийгдсэн ач холбогдол бүхий ажил гүйлгээний үнэ, нөхцөл нь ижил төрлийн бие даасан ажил гүйлгээний үнэ, нөхцөлөөс ялгаатай байгаагаас татварын суурь буурсан байж болзошгүй;

3.7.2. Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд заасан Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм хэрэгжүүлэхтэй холбоотой нарийн, төвөгтэй нөхцөл байдал үүссэн;

3.8.Нарийн төвөгтэй нөхцөл байдал үүссэн талаарх танилцуулгыг тухайн нөхцөл байдлыг тогтоосноос хойш ажлын 5 өдрийн дотор дараах агуулгын хүрээнд бичиж ирүүлнэ.

3.8.1. хяналт шалгалтад хамрагдсан хугацаа, үндэслэл;

3.8.2. харилцан хамаарлыг тогтоосон байдал;

3.8.3. татвар ногдох орлого, хөрөнгийн дүнг бууруулсан гэж үзсэн гол үндэслэл, тайлбар, тооцоолол;

3.8.4. татварын ерөнхий хуулийн 16.6-д заасан татварын ашиг хүртсэн эсэхийг тогтоосон үндэслэл;

3.8.5. тухайн нөхцөл байдлыг тодорхойлох анхан шатны баримт, гэрээ, холбогдох бусад баримт материал;

3.9 Энэ журмын 3.8-д заасан танилцуулгад үндэслэн Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж нь бусад нэгжтэй хамтран хяналт шалгалт хийх, эсхүл мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.10 Журмын 3.5-д заасан хяналт шалгалтыг хоёр ба түүнээс дээш татварын улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр, мөн журмын 3.6-д заасан хяналт шалгалтыг ажлын цар хүрээ, гүйцэтгэх ажлын шаардлага, хэрэгцээтэй мэргэжил, техник хэрэгсэл, тусгай мэргэшлийн ур чадвар зэргээс хамаарч багийн бүрэлдэхүүнтэй хийж болно.

3.11 Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж нь татвар төлөгчийн ангилал /сегмент/, үйл ажиллагааны цар хүрээнд үндэслэн татвар төлөгчийн нэг жилийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд зарцуулах хүн өдрийг жил бүрийн эхэнд тогтоож Эрсдэлийн удирдлагын нэгжид хүргүүлнэ.

3.12 Эрсдэлийн удирдлагын нэгж нь энэ журмын 3.11-д заасан хүн өдрийг үндэслэн татварын хяналт шалгалтыг хийх томилолтын хугацааг тодорхойлно.

3.13 Нарийн төвөгтэй хяналт шалгалтын томилолтын хугацааг тогтооход энэ журмын 3.12-т заасныг баримтлахгүй байж болох бөгөөд тусгай удирдамж гарсан тохиолдолд түүнд заасан хугацаатай уялдуулна. Энгийн хяналт шалгалтыг энэ журмын 3.7, 3.9-д заасан үндэслэлээр өөрчилсөн тохиолдолд шалгалтын хугацааг дахин тодорхойлно.

3.14 Хяналт шалгалт хийх томилолтын хугацааг хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга дараах үндэслэлээр сунгаж болно.

3.14.1. ажлын цар хүрээ өөрчлөгдсөн;

3.14.2. удирдлагын шийдвэрээр татварын улсын байцаагч нь өөр ажилд томилогдсон;

3.14.3. хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн;

3.14.4. мэдээлэл харилцан солилцох хүсэлт гаргасан;

3.15. Хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга дараах тохиолдолд томилолтыг өөрчилж болно:

3.15.1. энэ журмын 2.5-д заасан үндэслэлээр хяналт шалгалтын хэлбэрийг өөрчилсөн;

3.15.2. татварын улсын байцаагч татварын алба, нэгж хооронд сэлгэн ажилласан, бусад байгууллагад шилжсэн, албан ажлаас түр болон бүрэн чөлөөлөгдсөн;

3.15.3. татвар төлөгчийг хамгийн сүүлд шалгасан татварын улсын байцаагчид дахин томилолт олгогдсон;

3.15.4. энэ журмын 2.6.1-д заасан нарийн төвөгтэй хяналт шалгалт хийх багийн бүрэлдэхүүнд энэ журмын 3.15.3-д заалт хамаарахгүй;

3.15.5. татварын улсын байцаагч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд ашиг сонирхлын зөрчилтэй мэдүүлэг гаргасан;

3.15.6. хяналт шалгалтын төрлийг өөрчлөх шийдвэр гарсан;

3.16. Хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга дараах тохиолдолд томилолтыг цуцална.

3.16.1. татвар төлөгч хувь хүн нас барсан, нас барсанд тооцсон;

3.16.2. татвар төлөгчийг эрэн сурвалжлах шүүхийн тогтоолыг үндэслэн цагдаагийн байгууллагаас ажиллагаа явуулсан талаар тодорхойлолт гаргасан;

3.17. Журмын 3.16-д зааснаас бусад тохиолдолд томилолтыг цуцлахад татварын ерөнхий газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжээс зөвшөөрөл авна.

3.18. Хяналт шалгалтын томилолтыг цуцалсан нь татвар төлөгчийг дахин хяналт шалгалтад хамруулахгүй байх үндэслэл болохгүй.

Дөрөв. Хяналт шалгалтын үйл ажиллагаа

4.1 Татварын хяналт шалгалтын ажлыг бэлтгэх, гүйцэтгэх, дуусгах гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. Үе шат бүрт ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын гүйцэтгэлийг татварын удирдлагын нэгдсэн системд тухай бүр бүртгэн, өдөр тутам хийсэн ажлын тэмдэглэл хөтөлнө.

4.2 Бэлтгэх үе шатанд татварын улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1 татварын улсын байцаагч Татварын ерөнхий хуулийн 41.7-д зааснаас бусад тохиолдолд татвар төлөгчид хяналт шалгалт эхлэхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө шалгалт хийх талаар мэдэгдэж, хяналт шалгалт хийх томилолтыг биечлэн болон шуудангаар, төрийн байгууллагын цахим шуудангийн албан хаягаар хүргүүлнэ.

4.2.2 татвар төлөгчийн хууль ёсны төлөөлөгч, татвар төлөгчид шалгалтын зорилго, үндэслэл, хэлбэр, хамрагдах хугацаа, татварын алба, татварын улсын байцаагч, татвар төлөгчийн эрх, үүргийг танилцуулж, тайлбар авч ярилцлагын тэмдэглэл хөтөлж гарын үсэг зуруулна.

4.2.3 татварын хяналт шалгалтад шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээллийг ирүүлэх талаар “Баримт бичгийн хүсэлт”-ийг татвар төлөгчид биечлэн болон шуудангаар, төрийн байгууллагын цахим шуудангийн албан хаягаар хүргүүлж, хүргүүлсэн тухай тэмдэглэлийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэнэ.

4.2.4 татвар төлөгчийн энэ журмын 4.2.3-т заасан баримт бичиг, мэдээ, мэдээллийг “Хүлээн авсан баримт бичгийн бүртгэл”-ээр хүлээн авна. Шалгалтын явцад нэмж шаардсан баримт бичиг ирүүлсэн тохиолдолд тухай бүр нь бүртгэж хүлээн авна.

4.2.5 “Баримт бичгийн хүсэлт”-ээр шаардсан баримт бичиг, мэдээ мэдээллийг татвар төлөгч тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол энэ талаар ярилцлагын тэмдэглэл хөтөлж, тайлбар гаргуулан авна.

4.2.6 татвар төлөгч энэ журмын 1.6-д заасан нөхцөл байдал үүссэн, татвар төлөгчтэй биечлэн уулзах боломжгүй болон бусад тохиолдолд татварын улсын байцаагчаас цахимаар ирүүлсэн хяналт шалгалт хийх томилолт, баримт бичгийн хүсэлт зэрэгтэй танилцан хяналт шалгалтын үйл ажиллагаанд аль болох хүндрэл учруулахгүйгээр үйл ажиллагааныхаа талаар ярилцлага өгөх, шаардсан баримтыг цахимаар явуулна.

4.2.7 татвар төлөгчтэй биечлэн уулзах боломжгүй тохиолдолд ярилцлагын тэмдэглэлийг утсаар, цаасан болон цахим хэлбэрээр баримтжуулж, татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэнэ.

4.2.8 татварын улсын байцаагч нь татварын хяналт шалгалтыг цахимаар хийхдээ Татварын ерөнхий газрын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжээс гаргасан “Ажлын байрны гаднаас татварын албаны мэдээллийн системд ажиллах зөвлөмж”-ийг хэрэгжүүлэн ажиллана.

4.2.9 татвар төлөгчийн хувийн хэрэг, тайлан, тодруулга, мэдээлэл, судалгаа, үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллүүдийг дотоод, гадаад эх үүсвэрээс цуглуулж дараах судалгаа шинжилгээг хийнэ.

4.2.9.1 татвар төлөгчийн эрхэлж буй өөрийн болон салбарын үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл, эдийн засаг, зах зээлийн төлөв байдлын;

4.2.9.2 татвар төлөгчийн татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан дахь бүртгэл, ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын мэдээлэлд;

4.2.9.3 санхүү, татварын тайлан, хувьцаа, хөрөнгө оруулалтын мэдээлэлд шинжилгээ хийж, гол үзүүлэлтүүдийг салбарын үзүүлэлттэй харьцуулах;

4.2.9.4 татварын албаны хөндлөнгийн мэдээллийг татварын тайлангийн үзүүлэлттэй харьцуулах;

4.2.9.5 татварын хяналт шалгалтад хамрагдсан байдал, илэрсэн зөрчлүүд, бүх шатны маргааны шийдвэрлэлтийн үр дүнд;

4.2.9.6 татварын албаны эрсдэлийн үнэлгээний үзүүлэлт болон эрсдэлийн удирдлагын нэгжээс ирүүлсэн бусад мэдээлэлд;

4.2.9.7 тухайн салбарын онцлог, хяналт шалгалтын цар хүрээнээс хамаарч мэргэжлийн шинжээчийн гаргасан зөвлөмж, дүгнэлтэд;

4.2.9.8 бусад шаардлагатай мэдээлэлд;

4.2.10 татварын улсын байцаагч энэ журмын 4.2.9-д заасан судалгаа, шинжилгээ, цуглуулсан мэдээлэлд үндэслэн хяналт шалгалтын үйл ажиллагааг ач холбогдлоор нь эрэмбэлэн, дарааллыг нарийвчлан тогтоож, гүйцэтгэх үе шатанд хэрэгжүүлэх “Татварын хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /цаашид “ажлын төлөвлөгөө” гэх/ гаргана.

4.3 Гүйцэтгэх үе шатанд татварын улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1 хяналт шалгалтыг энэ журмын 4.2.10-д заасан ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх бөгөөд нэгжийн дарга шаардлагатай тохиолдолд ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийнэ;

4.3.2 хяналт шалгалт хийхээр томилогдсон татварын улсын байцаагч нь хяналт шалгалтыг өөрийн ажлын байранд хийнэ. Хэрэв хяналт шалгалтыг татвар төлөгчийн хүсэлтээр түүний ажлын байранд хийхээр бол хяналт шалгалтын нэгжийн даргад танилцуулж, татвар төлөгчөөр ажлын түр байр гаргуулан хийж болно. Энэ журмын 1.6-д заасан нөхцөл байдал үүссэн үед журмын 4.2.8-д заасныг хэрэгжүүлж ажиллана;

4.3.3 хяналт шалгалтын явцад зөрчилтэй байж болзошгүй гэж үзсэн мэдээ, мэдээллийг татвар төлөгчөөс тодруулах, тооцоо нийлэх, баримтын тулгалт хийх, нэмэлт баримт бичиг, тооцоо судалгаа гаргуулах, шаардлагатай тохиолдолд гуравдагч этгээдээс баримт материал гаргуулан авч баримтжуулах, зөрчлийг нотлох, тогтоох ажиллагааг гүйцэтгэх;

4.3.4 хяналт шалгалтын явцад зөрчилтэй байж болзошгүй гэж үзсэн мэдээллийг нотлох зорилгоор гол харилцагч татвар төлөгчдийн талаар тайлбар, тодруулга, мэдээлэл, лавлагааг бусад татварын албанд хүсэлт хүргүүлэн авах;

4.3.5 хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг баримтжуулах, тодруулах, хяналт шалгалтын хугацаанд шаардлагатай мэдээллийг олж авах, нэмэлт мэдээллийн эх сурвалжийг илрүүлэх, мэдээллийн сангийн мэдээллийн үнэн зөв эсэхийг нотлох зорилгоор татвар төлөгч болон холбогдох хүмүүстэй ярилцлага хийж, тухай бүр “Ярилцлагын тэмдэглэл” хөтлөх;

4.3.6 хяналт шалгалттай холбоотой асуудлаар биечлэн уулзах хүсэлтэй иргэд, албан тушаалтныг ажлын цагаар хүлээн авч, мэдээлэл, санал, хүсэлтийн талаар “Ярилцлагын тэмдэглэл” хөтлөх;

4.3.7 хяналт шалгалтын явцад цуглуулсан холбогдох баримт бичигт үндэслэн хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил бүрт дэлгэрэнгүй жагсаалт, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай баримт бичгийг хувиалан авах, тайлбар тодруулга гаргуулах зэргээр зөрчлийг баримтжуулах;

4.3.8 хяналт шалгалтад хамрагдсан татварын төрөл тус бүрийн ногдуулалт, төсөвт төлсөн, суутган тооцсон татварын дүнг үндсэн баримтаар нь хянан шалгаж илүү, дутуу төлөлтийн тооцоог тулган баталгаажуулах;

4.3.9 шаардлагатай тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох мэргэжлийн байгууллагаас лавлагаа тодруулга гаргуулах, шинжилгээ хийлгэх, мэргэжлийн туслалцаа авах зэргээр хамтран ажиллах;

4.3.10 энэ журмын 4.3.4-д заасан мэдээллийг тодруулах шаардлага үүссэн тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 41.10.1-д заасны дагуу харилцагч этгээдээс

тайлбар авах бөгөөд мөн хуулийн 21.4-т заасан мэдээ, мэдээлэл, баримтыг гуравдагч этгээдээс гаргуулах;

4.3.11.хяналт шалгалт хийх явцад Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд заасан нөхцөлийг бүрдүүлж байгаа татвар төлөгчийн үйлдлийг тогтоосон тохиолдолд тухайн татварын албаны даргад танилцуулан Эрсдэлийн удирдлагын хороонд хүсэлт гаргах;

4.3.12.хяналт шалгалт хийх явцад Татварын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд заасныг зөрчсөн байж болзошгүй тохиолдолд харьяа нэгж нь үнэ шилжилт хариуцсан нэгжид шилжүүлэх;

4.3.13.хяналт шалгалтын явцад зөрчилтэй байж болзошгүй гэж үзсэн мэдээ, мэдээллийг тодруулах, нэмэлт баримт бичиг, тооцоо судалгааг гадаад улсын эрх бүхий этгээдээс гаргуулахаар Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэл авах хүсэлтийг мэдээлэл харилцан солилцох асуудал хариуцсан нэгжид гаргах;

4.3.14.хяналт шалгалтын явцад татвар төлөгчийн гадаад улсад төлсөн албан татварыг баталгаажуулах тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэл авах хүсэлтийг мэдээлэл харилцан солилцох асуудал хариуцсан нэгжид гаргах;

4.3.15.хяналт шалгалт хийх явцад олон улсын жишигт нийцсэн татварын хяналт шалгалтын арга, техникийг ашиглан дараах тусгайлсан үйл ажиллагааг нарийвчлан хэрэгжүүлнэ:

4.3.15.1 татварын ногдлыг бууруулах, татварын суурь багасгах, эсхүл алдагдлыг нэмэгдүүлэх замаар татварын ашиг хүртсэн этгээдэд Эрсдэлийн удирдлагын хорооноос ирүүлсэн шийдвэрийг үндэслэн татварын ногдолд залруулга хийх;

4.3.15.2 харилцан хамааралтай этгээд хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөл татварын зорилгоор түүнтэй харьцуулж болох бие даасан ажил гүйлгээний нөхцөлөөс ялгаатай тохиолдолд татварын суурь багассан этгээдэд Татварын ерөнхий хуулийн 39, 40.6-д заасны дагуу үнэ шилжилтийн үндсэн болон хоёрдогч тохируулгыг хийх;

4.3.15.3 Татвар төлөгчид хяналт шалгалт хийхдээ гадаад улсад олсон тухайлсан орлоготой холбоотой гүйлгээг санхүүгийн холбогдох баримт болон гуравдагч этгээдийн мэдээллээр нотлох;

4.3.15.4 толгой компаниас төлөөний газарт хамаарах татвар ногдох орлого, хуваарилагдсан зардлыг тодорхойлохдоо хууль тогтоомж, давхар татварын гэрээ, түүний заавар, холбогдох журамд нийцсэн эсэхийг шалгах;

4.3.16 энэ журмын 4.3.1, 4.3.2, 4.3.3, 4.3.4, 4.3.5, 4.3.6, 4.3.7, 4.3.8, 4.3.9, 4.3.10, 4.3.11, 4.3.12, 4.3.13, 4.3.14, 4.3.15-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд нотлогдсон зөрчлийг бүртгэж, ногдуулах нөхөн татвар, торгууль, алданги, хүүг тооцох;

4.3.17 татвар төлөгчийн тайлагнасан, хяналт шалгалтаар тогтоосон татварын ногдуулалт төлөлтийн тооцоог шалгалтад хамрагдсан татварын төрөл, он тус бүрээр хийх;

4.3.18 энэ журмын 4.3.8-д заасан баталгаажуулалтаар хуулийн хугацаанд төлөөгүй татварт торгууль, алданги тооцох;

4.4 Дуусгах үе шатанд татварын улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. энэ журмын 4.3.16, 4.3.17, 4.3.18-д заасан зөрчил, түүний хууль эрх зүйн үндэслэл, тооцооллыг тухайн шатны хяналт шалгалт хариуцсан чиг үүрэг бүхий нэгжийн даргад танилцуулж, хянуулах;

4.4.2. энэ журмын 4.3.16, 4.3.17, 4.3.18-д заасан зөрчил, түүний хууль эрх зүйн үндэслэл, тооцоололд өөрчлөлт оруулах асуудлаар Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжээс мэргэжил арга зүйн чиглэл өгнө;

4.4.3. журмын 4.4.2-т заасан мэргэжил арга зүйн чиглэлээр өөрчлөлт оруулсан бол хууль зүйн үндэслэл, нотлох баримт зэргийг холбогдох албан тушаалтан мэдээллийн системд бүртгэх;

4.4.4. журмын 4.4.2-т заасан мэргэжил арга зүйн чиглэлийг хүлээж авах эсэхийг хяналт шалгалтыг хийж, хяналт тавьж байгаа хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга, байцаагчид эцэслэн шийдвэрлэж, хариу мэдэгдэх;

4.4.5. татварын хяналт шалгалтын үр дүнг тодорхойлоход хангалттай мэдээлэл, нотлох баримт, тооцооллыг нягталж шийдвэр гаргахад бэлтгэх;

4.4.6. хяналт шалгалтын ажлын үр дүнгээр татварын акт, шийтгэлийн хуудас, илтгэх хуудас үйлдэж, хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэг дарж, хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн дарга хянан баталгаажуулж гарын үсэг зурж, тэмдэг дарснаар шийдвэр хүчин төгөлдөр болно;

4.4.7. хяналт шалгалтын ажлын үр дүнгээр шаардлагатай тохиолдолд танилцуулга бичиж болно.

4.4.8. татварын алба, татварын улсын байцаагч нь эцэслэн баталгаажуулаагүй шийдвэрийг татвар төлөгчид урьдчилан танилцуулахгүй.

4.4.9. татварын акт, илтгэх хуудсыг хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 7 өдрийн дотор татвар төлөгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид гардуулж, гардуулсан тухай тэмдэглэл үйлдэх;

4.4.10. татварын акт, илтгэх хуудсыг энэ журмын 4.4.9-д заасан хугацаанд гардуулах боломжгүй, эсхүл гардан аваагүй бол уг хугацаа өнгөрснөөс хойш 7 хоногийн дотор татвар төлөгчийн хаягаар шуудангаар илгээх;

4.4.11. энэ журмын 4.4.10-д заасан шуудангаар илгээсэн боловч хаяг байршилдаа байхгүй болон бусад шалтгаанаар буцаж ирсэн татварын акт, илтгэх хуудсыг Татварын ерөнхий хуулийн 42.8-д заасны дагуу татвар төлөгчид гардуулсанд тооцон, татварын улсын байцаагч тэмдэглэл үйлдэн, татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэж, хяналт шалгалтын баримтад шийдвэрийг хавсаргах;

4.4.12. энэ журмын 4.4.9-д заасан татварын акт, илтгэх хуудсыг гардуулахдаа хууль тогтоомжид заасны дагуу гомдол, хүсэлт гаргах эрхтэйг танилцуулж, гарын үсэг зуруулах;

4.4.13. хяналт шалгалтын ажил бүрэн дууссан тохиолдолд энэ журмын 4.2.4-т заасан баримт бичгийг татвар төлөгчид “Хүлээлгэн өгсөн баримт бичгийн бүртгэл”-ээр хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулах;

4.4.14. хяналт шалгалтын явцад бусад татвар төлөгчдийн татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой цаашид хөндлөнгийн мэдээллээр ашиглах гэрээ, төлбөр, тооцооны болон бусад баримтыг мэдээллийн санд бүртгэх;

4.5. Татварын ерөнхий хуулийн 44.1-д заасны дагуу хяналт шалгалтыг хийх явцад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил илэрсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Тав.Татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд татвар төлөгчийн оролцоо

5.1. Татвар төлөгч нь татварын хяналт шалгалтын удирдамж, томилолттой танилцсанаар энэ журмын 4.2.3-т заасан баримт бичгийг татварын албаны тогтоосон хугацаанд бэлтгэж хүргүүлнэ.

5.2. Энэ журмын 5.1-д заасан баримт, бичиг нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол Татварын ерөнхий хуулийн 29.1.4-т заасны дагуу татвар төлөгч монгол хэл дээр орчуулж татварын албанд ирүүлнэ.

5.3. Татвар төлөгч нь хяналт шалгалтын ажил эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө татварын албанд дараах хүсэлтийг гаргаж болно:

5.3.1. Татварын ерөнхий хуулийн 6.1.41-д заасан хүндэтгэн үзэх шалтгаан үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг хойшлуулах;

5.3.2. хяналт шалгалт хийх татварын улсын байцаагчтай Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зөрчил үүссэн бол татварын улсын байцаагчийг өөрчлүүлэх;

5.4. Татвар төлөгч нь татварын хяналт шалгалтыг томилолтын хугацаанд шуурхай хийх нөхцөл боломжоор хангана.

5.5. Татварын алба нь татварын хяналт шалгалт хийхээр татвар төлөгчид мэдэгдсэнээс хойш хяналт шалгалтад хамрагдаж буй хугацаанд хамаарах тайлангийн Татварын ерөнхий хуулийн 31.4-т заасны дагуу залруулах болон хугацааг сунгуулах хүсэлт хүлээн авахгүй.

5.6. Татвар төлөгч нь энэ журмын 4.3, 4.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад татварын улсын байцаагчид тайлбарыг нотлох баримтыг шаардсан тухай бүр цахим болон цаасан хэлбэрээр гаргаж өгнө.

5.7. Татвар төлөгч нь татварын албанаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 30 хоногийн дотор захиргааны болон шүүхийн журмаар гомдлоо гаргана.

5.8. Татвар төлөгчийн татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой шинээр үүссэн нөхцөл, хөндлөнгийн мэдээлэл нь хяналт шалгалтад дахин хамруулах үндэслэл болно.

Зургаа. Хяналт шалгалтын акт, илтгэх хуудас үйлдэх, түүний биелэлтийг хангуулах

6.1. “Нөхөн ногдуулалтын акт”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан шалгаж баталгаажуулсан акт”, “Буцаан олголтын акт”, “Илтгэх хуудас” нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталсан хэвлэмэл хуудас байна.

6.2. Журмын 4.4.6-д заасан акт, илтгэх хуудас нь нэгдсэн бүртгэл, дугаартай байх бөгөөд хавсралтын хамт хүчинтэй байна.

6.3. Татварын акт, илтгэх хуудсыг 3 хувь үйлдэх бөгөөд нэг дэх хувийг хяналт шалгалтын нэгжийн баримтад, хоёр дахь хувийг татвар төлөгчид, гурав дахь хувийг татвар төлөгчийн хувийн хэрэг хариуцсан нэгжид тухай бүр шилжүүлнэ.

6.4. Харьяа нэгж нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан баталгаажуулсан саналыг том татвар төлөгчтэй харилцах нэгжид, том татвар төлөгчтэй харилцах нэгж нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан шалгаж баталгаажуулсан акт”-ыг 4 хувь үйлдэж, Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, харьяа нэгжид, татвар төлөгчид хүргүүлнэ.

6.5. Нөхөн ногдуулалтын акт нь тэмдэглэх болон тогтоох, илтгэх хуудас нь тэмдэглэх хэсгээс бүрдэнэ.

6.5.1. тэмдэглэх хэсэгт: татварын хяналт шалгалтад хамрагдаж байгаа татвар төлөгчийн мэдээлэл, татварын хяналт шалгалт хийх үндэслэл, өмнө татварын хяналт шалгалтад хамрагдсан байдал шийдвэрлэлт, татвар төлөгчийн татварын ногдуулалт, төлөлтийн байдал /татварын төрөл, он тус бүрээр/, хөндлөнгийн мэдээллийн ашиглалт, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн утга, дүн, зөрчсөн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, татварын акт үйлдэх үндэслэлийг;

6.5.2. тогтоох хэсэгт: Татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид хариуцлага хүлээлгэсэн хуулийн зүйл, хэсэг, заалт, баталгаажуулсан үлдэгдлийн дүн, төлүүлэхээр шийдвэрлэсэн нөхөн татвар, алданги, торгуулийн дүн, төлбөрийг хүлээн авах Татварын алба, банкны нэр, дансны дугаар, төлбөр хийх хугацааг;

6.5.3. тогтоох хэсгийн төгсгөлд нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудас үйлдсэн татварын алба, татварын улсын байцаагчийн нэр, гарын үсэг, танилцсан татвар төлөгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, гарын үсэг, зөвшөөрсөн эсэх, хянан

баталгаажуулсан хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн даргын нэр, огноо, гарын үсэг, тэмдэг дарна.

6.6. Татварын акт, илтгэх хуудсанд дараах баталгаажуулсан маягтыг хавсаргана:

6.6.1. “Татварын хяналт шалгалт хийх томилолт” Маягт-ХШ01

6.6.2. “Ярилцлагын тэмдэглэл” Маягт-ХШ03

6.6.3. “Татварын хяналт шалгалтын ажлын карт” Маягт-ХШ06/01/

6.6.4. “Татварын хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил, ногдуулсан төлбөрийн тооцоо” Маягт-ХШ06/02/

6.6.5. “Татвар /төлбөр/-ын ногдуулалт, төлөлтийн тооцоо” Маягт-ХШ07/01-12/

6.6.6. “Хуулийн хугацаанд төлөөгүй татварт торгууль, алданги ногдуулсан тооцоо” Маягт-ХШ08

6.6.7. “Нөхөн ногдуулалтын акт, /илтгэх хуудас/-ийг танилцуулсан тухай тэмдэглэл” Маягт-ХШ09 үйлдэнэ.

6.6.8. “Аж ахуйн нэгжийн тайлангаар гарсан алдагдлыг баталгаажуулсан тооцоо” Маягт-ХШ11.

6.6.9. Нарийн төвөгтэй хяналт шалгалт хийсэн тохиолдолд хяналт шалгалтын ажлын тайлан

6.6.10. Татварын хяналт шалгалт хийсэн нэгж болон татварын улсын байцаагч нь хяналт шалгалтын шийдвэрийг татварын удирдлагын нэгдсэн системд үнэн зөв бүртгэгдсэн, ногдуулсан төлбөрийн өр бүрэн үүссэн эсэхэд хяналт тавьж, хариуцаж ажиллана.

6.6.11. Маргаан бүхий актны шийдвэрлэлтийн явцад хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагч биечлэн оролцож, хариуцаж ажиллана.

6.6.12. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг Татварын удирдлагын нэгдсэн системд Маргаан таслах зөвлөлийн магадлагч, хуулийн мэргэжилтэн бүртгэж, харьяалах татварын албаны хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана.

6.7. Татвар төлөгч шилжсэн үед маргаан бүхий актын шийдвэрлэлтэд шилжүүлэн авсан татварын албаны хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж хяналт тавина.



Монголын Татварын Алба Маягт-ХШ01

ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ТОМИЛОЛТ

Дугаар

1. Томилсон: 20... он ... сар ... өдөр
2. Татварын албаны нэр:
3. Татварын хяналт шалгалтын багийн ахлагч
Татварын улсын (ахлах) байцаагчийн нэр:
- Татварын улсын (ахлах) байцаагчийн нэр:
4. Татвар төлөгчийн нэр, хариуцлагын хэлбэр, регистр:
5. Татварын хяналт шалгалтад хамрагдах хугацаа:
6. Татварын хяналт шалгалтын төрөл:
 - 6.1. төлөвлөгөөт () Хэсэгчилсэн () Татан буугдах ()
 - 6.2. алдагдал баталгаажуулах () шийдвэрээр () гомдлоор ()
 - 6.3. НӨАТ баталгаажуулах ()
 - 6.4. бусад ()
7. Татварын хяналт шалгалт эхлэх, зарцуулах хугацаа: 20...он...сар...өдөр |_|_| хоног
8. Татварын хяналт шалгалтын газар, хэлтэс (тасаг)-ийн дарга
..... / /
тэмдэг гарын үсэг нэр
9. Сунгалт хийсэн: 20...он...сар...өдөр
Сунгасан хугацаа: 20...он...сар...өдрийг хүртэл |_|_| хоног
10. Татварын хяналт шалгалтын газар, хэлтэс (тасаг)-ийн дарга
..... / /
тэмдэг гарын үсэг нэр
11. Өөрчлөлт хийсэн хугацаа: 20... он ... сар ... өдрийг хүртэл |_|_| хоног
Татварын улсын (ахлах) байцаагч:
..... / /
тэмдэг гарын үсэг нэр
Татварын хяналт шалгалтын газар, хэлтэс (тасаг)-ийн дарга:
..... / /
тэмдэг гарын үсэг нэр
12. Цуцалсан: 20...он...сар...өдөр
Татварын хяналт шалгалтын газар, хэлтэс (тасаг)-ийн дарга:
..... / /
тэмдэг гарын үсэг нэр



Монголын Татварын Алба

Маягт-ХШ03

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар

20... он ... сар ... өдөр

..... хот аймаг

1. Томилолтын дугаар
2. Татвар төлөгчийн нэр, өмчийн хэлбэр:
3. Регистрийн дугаар:
4. Ярилцлагад оролцсон:
Албан тушаал Овог Нэр Утас
- Албан тушаал Овог Нэр Утас
5. Татварын хяналт шалгалтад хамрагдах татвар төлөгчийн хаяг, байршил:
.....
6. Ярилцлагын утга агуулга:
.....
.....
.....
.....
7. Урьд нь хийсэн татварын хяналт шалгалтаар төлүүлэхээр шийдвэрлэсэн төлбөрийг
бүрэн барагдуулаагүйн шалтгаан:
.....
.....
8. Шаардлагатай бусад асуудлууд:
.....
.....
.....

Харилцан ярилцсан:

Татварын улсын (ахлах) байцаагч:

Албан тушаал, овог нэр:

..... / /
гарын үсэг / нэр

тэмдэг

..... / /
гарын үсэг / нэр

тэмдэг



Монголын Татварын Алба

Маягт-ХШ06/01/

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН КАРТ /акт/

Дугаар

20... он ... сар ... өдөр

1. Татварын албаны нэр:
2. Татвар төлөгчийн нэр, хариуцлагын хэлбэр:
3. Татварын хяналт шалгалтын төрөл:
4. Татварын хяналт шалгалтад хамруулахаар сонгосон үндэслэл:
 - 4.1. Эрсдэлийн үнэлгээ
5. Татварын хяналт шалгалтад зарцуулах хүн өдөр:
6. Татварын хяналт шалгалт хийх Татварын улсын (ахлах) байцаагчийн нэр:
.....
.....
7. Татварын хяналт шалгалтад томилсон:
8. Татварын хяналт шалгалтын газар, хэлтэс /тасаг/-ийн даргын нэр:
.....
.....
9. Шийдвэрлэлтийн байдал:
10. Татварын хяналт шалгалтад хамруулсан хугацаа:
11. Илрүүлсэн зөрчил:

| Зөрчлийн | | | | | | Дүн/төгрөг/ |
|--------------------|--|--|--|--|--|-------------|
| Код, Төрөл, Хэлбэр | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| Нийт дүн | | | | | | |

Карт хөтөлсөн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

тэмдэг

.....
гарын үсэг

/ /
нэр



Монголын Татварын Алба

Маягт-ХШ06/02/

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

.....- д ХИЙСЭН ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛРҮҮЛСЭН
ЗӨРЧИЛ, НОГДУУЛСАН ТӨЛБӨРИЙН ТООЦОО

Дугаар

| Д/д | Илрүүлсэн зөрчлийн | | | Зөрчлийн дүн | Алдагдал бууруулах дүн | Хариуцлага тооцсон хуулийн заалт | Ногдуулсан | | | | | Буцаан олгох татварын дүн | Зөвшөөрсөн эсэх /тийм, үгүй/ | Татвар төлөгчийн гарын үсэг |
|-----|--------------------|-------------------|-------------------|-----------------|------------------------------|-------------------------------------------|-----------------|----------|---------|-----|--------------------------|------------------------------------|------------------------------------|-----------------------------------|
| | Утга, агуулга | Татварын төрөл | Хамаарах огноо | | | | нөхөн татвар | торгууль | алданги | хүү | Нийт төлбөрийн дүн | | | |
| | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | |
| | Нийт дүн | | | | | | | | | | | | | |
| | Үүнээс: | Зөвшөөрсөн | | | | | | | | | | | | |
| | | Зөвшөөрөөгүй | | | | | | | | | | | | |

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг / нэр

тэмдэг

Танилцсан: захирал

..... / /
гарын үсэг / нэр

Нягтлан бодогч:

..... / /
Тамга, тэмдэг / гарын үсэг / нэр



Татварын хяналт шалгалтын үйл
ажилллагааны журмын ... дугаар хавсралт

Монголын Татварын Алба

Маягт-ХШ07/02/

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

“.....” ХХК-ийн ЦАЛИН ХӨЛС, ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО БОЛОН ШУУД БУС ОРЛОГООС СУУТГАСАН АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО

| Д/Д | Үзүүлэлт |ОН | | Зөрүү |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------|------------|------------|-------|
| | | Тайлангаар | Шалгалтаар | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | | | |
| 2 | Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн дүн | | | |
| 3 | Албан татвар ногдуулах орлогын дүн | | | |
| 4 | Ногдуулсан албан татварын дүн | | | |
| 5 | Хөнгөлөгдөх татварын дүн | | | |
| 6 | Суутгавал зохих татварын дүн | | | |
| 7 | Татвар ногдох шууд бус орлогын дүн | | | |
| 8 | Шууд бус орлогод ногдуулсан татвар | | | |
| 9 | Нийт төлбөл зохих татварын дүн | | | |
| 10 | Тайлант хугацааны эхний илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 11 | Бусад татварын илүүгээс суутган тооцооллоор хаасан дүн | | | |
| 12 | Төлсөн татвар | | | |
| 13 | Эцсийн тооцоогоор гарсан илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 14 | Ногдуулсан торгууль | | | |
| 15 | Ногдуулсан алданги | | | |
| 16 | НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР | | | |

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Нягтлан бодогч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг



Монголын Татварын Алба

Маягт-ХШ07/03/

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

“.....” ХХК-ийн СУУТГАГЧИЙН ХУВЬ ХҮНД ОЛГОСОН ОРЛОГООС СУУТГАСАН АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО

| Д/Д | Үзүүлэлт | 20... он | | Зөрүү |
|-----|--------------------------------------------------------|------------|------------|-------|
| | | Тайлангаар | Шалгалтаар | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Суутгагчийн хувь хүнд олгосон нийт орлого | | | |
| 2 | Суутгасан нийт татварын дүн | | | |
| 3 | Тайлант хугацааны эхний илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 4 | Бусад татварын илүүгээс суутган тооцооллоор хаасан дүн | | | |
| 5 | Төлсөн татвар | | | |
| 6 | Эцсийн тооцоогоор гарсан илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 7 | Ногдуулсан торгууль | | | |
| 8 | Ногдуулсан алданги | | | |
| 9 | НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР | | | |

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Нягтлан бодогч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг



Монголын Татварын Алба

Маягт-ХШ07/04/

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

“.....” ХХК-ийн АЖ АХУЙН НЭГЖИД ОЛГОСОН ОРЛОГООС СУУТГАСАН АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО

| д/д | Үзүүлэлт | 20... он | | Зөрүү |
|-----|-----------------------------------------------------------------------|------------|------------|-------|
| | | Тайлангаар | Шалгалтаар | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Суутгагчийн аж ахуйн нэгжид олгосон нийт татвар ногдуулах орлогын дүн | | | |
| 2 | Суутгасан нийт татварын дүн | | | |
| 3 | Давхар татварын гэрээгээр өөрчлөгдсөн татварын дүн | | | |
| 4 | Суутгавал зохих нийт татварын дүн | | | |
| 5 | Тайлант хугацааны эхний илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 6 | Бусад татварын илүүгээс суутган тооцооллоор хаасан дүн | | | |
| 7 | Төлсөн татвар | | | |
| 8 | Эцсийн тооцоогоор гарсан илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 9 | Ногдуулсан торгууль | | | |
| 10 | Ногдуулсан алданги | | | |
| 11 | НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР | | | |

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Нягтлан бодогч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг



Монголын Татварын Алба Маягт-ХШ07/08/

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

“.....” ХХК-ийн АТӨЯХ-ийн АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО

| Д/д | Үзүүлэлт | 20..... он | | Зөрүү |
|-----|-----------------------------------------------------------|------------|------------|-------|
| | | Тайлангаар | Шалгалтаар | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Ногдуулсан албан татварын дүн | | | |
| 2 | Тайлант хугацааны эхний илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 3 | Бусад татварын илүүгээс суутган тооцооллоор хаасан дүн | | | |
| 4 | Төсөвт төлсөн татварын дүн | | | |
| 5 | Эцсийн тооцоогоор гарсан илүү (+), дутуу (-) үлдэгдэл | | | |
| 6 | Ногдуулсан торгууль | | | |
| 7 | Ногдуулсан алданги | | | |
| 8 | НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР | | | |

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Нягтлан бодогч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг



Монголын Татварын Алба Маягт-ХШ07/10в/

Татварын улсын байцаагчийн тоот акт, илтгэх хуудасны хавсралт

“.....” ХХК-ийн ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО /Тамхи/

| д/д | Үзүүлэлт | 20.....он | | Зөрүү |
|-----|-------------------------------------------------------------------------------|---------------------|------------|-------|
| | | Тайлангаар | Шалгалтаар | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Янжуур тамхины борлуулалтын нийт орлогын дүн | | | |
| 2 | Тайлангийн хугацаанд янжуур тамхинд ногдуулсан ОАТ-ын нийт дүн | | | |
| 3 | ОАТ-ын эхний үлдэгдэл | илүү дутуу | | |
| 4 | Тайлант хугацаанд төсөвт төлсөн ОАТ-ын дүн | | | |
| 5 | Худалдсан янжуур тамхинд зарцуулсан импортын задгай тамхинд төлсөн ОАТ-ын дүн | | | |
| 6 | ОАТ-ын эцсийн үлдэгдэл | илүү дутуу | | |
| 7 | Ногдуулсан | торгууль алданги | | |
| 8 | Дүнсэн тамхины борлуулалтын орлогын нийт дүн | | | |
| 9 | Тайлант хугацаанд дүнсэн тамхинд ногдуулсан ОАТ-ын нийт дүн | | | |
| 10 | ОАТ-ын эхний үлдэгдэл | илүү дутуу | | |
| 11 | Тайлангийн хугацаанд төсөвт төлсөн ОАТ-ын дүн | | | |
| 12 | ОАТ-ын эцсийн үлдэгдэл | илүү дутуу | | |
| 13 | Ногдуулсан | торгууль алданги | | |
| | НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР | | | |

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Нягтлан бодогч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг



Монголын Татварын Алба

Маягт-ХШ07/10г/

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

“.....” ХХК-ийн ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО /Автобензин, Дизелийн түлш/

| д/д | Үзүүлэлт | 20... он | | Зөрүү |
|----------------------|---------------------------------------------------|------------|------------|-------|
| | | Тайлангаар | Шалгалтаар | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Тайлангийн эхний үлдэгдэл | илүү | | |
| | | дутуу | | |
| 2 | Нийт ногдуулсан татварын дүн | | | |
| 3 | Тайлангийн хугацаанд төлбөл зохих татвар, бүгд | | | |
| 4 | Тайлангийн хугацаанд төлсөн татвар, бүгд | | | |
| 5 | Тайлангийн эцсийн үлдэгдэл | илүү | | |
| | | дутуу | | |
| 6 | Ногдуулсан | торгууль | | |
| | | алданги | | |
| НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР | | | | |

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг

Нягтлан бодогч:

..... / /
гарын үсэг / нэр
тэмдэг



Монголын Татварын Алба

Маягт-ХШ08

Татварын улсын байцаагчийн тоот акт, илтгэх хуудасны хавсралт

ХУУЛИЙН ХУГАЦААНД НЬ ТӨЛӨӨГҮЙ ТАТВАРТ ТОРГУУЛЬ, АЛДАНГИ НОГДУУЛСАН ТООЦОО

Татвар төлөгчийн нэр:

20... он ... сар ... өдөр

/төгрөгөөр/

| Сар | Төлбөл, шилжүүлбэл зохих | | Төлсөн, шилжүүлсэн | | Зөрүү | | Хугацаа хэтэрсэн хоног | Ногдуулсан торгууль | Тооцсон алданги | Нийт |
|----------------------|--------------------------|-----|--------------------|-----|-------|-------|------------------------|---------------------|-----------------|------|
| | хугацаа | дүн | хугацаа | дүн | илүү | дутуу | | | | |
| Эхний үлдэгдэл | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | |
| 1 дүгээр улирлын дүн | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | |
| 2 дугаар улирлын дүн | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | |
| 3 дугаар улирлын дүн | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | |
| 11 | | | | | | | | | | |
| 12 | | | | | | | | | | |
| 4 дүгээр улирлын дүн | | | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | | | |
| Эхний үлдэгдэл | | | | | | | | | | |
| Бүгд | | | | | | | | | | |

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... /

гарын үсэг

нэр

тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... /

гарын үсэг

нэр

тэмдэг

Нягтлан бодогч:

..... /

гарын үсэг

нэр

тэмдэг



Монголын Татварын Алба

Маягт-ХШ11

Татварын улсын байцаагчийн тоот
акт, илтгэх хуудасны хавсралт

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАНГААР ГАРСАН АЛДАГДЛЫГ ИРЭЭДҮЙД ШИЛЖҮҮЛСЭН ТООЦОО

..... он

| Үзүүлэлт | | Алдагдлын дүн | | Зөрүү |
|---------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|------------------------------|--------------------------|-------|
| | | Татвар төлөгч тайлагнасан | Татварын алба хянасан | |
| 1.Татварын албаар баталгаажуулсан өмнөх жилүүдийн алдагдал | а/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | б/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | в/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | г/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | д/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| 2.Тайлант жилийн татвар ногдуулах орлого | | | | |
| 3.Тайлант онд урьд жилүүдийн алдагдлаас шилжүүлэн тооцсон /хассан/ дүн | а/..... оны алдагдлаас шилжүүлсэн дүн | | | |
| | б/..... оны алдагдлаас шилжүүлсэн дүн | | | |
| | в/..... оны алдагдлаас шилжүүлсэн дүн | | | |
| | г/..... оны алдагдлаас шилжүүлсэн дүн | | | |
| | д/..... оны алдагдлаас шилжүүлсэн дүн | | | |
| | Нийт шилжүүлсэн алдагдлын дүн | | | |
| 4.Шилжээгүй үлдсэн алдагдал | а/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | б/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | в/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | г/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |
| | д/..... оны алдагдал /шилжүүлэх жил/ | | | |

Жич: Зөрүү баганад бичигдсэн тоо нь алдагдлыг шилжүүлэн тооцоход гаргасан зөрчил байх бөгөөд хяналт шалгалтын зөрчлийн жагсаалтын дүнд орно.

Тооцоог үйлдсэн:

Татварын улсын (ахлах) байцаагч:

..... / /
гарын үсэг нэр

Тэмдэг

Танилцаж зөвшөөрсөн:

Татвар төлөгч:

..... / /
гарын үсэг нэр

Тэмдэг